# ДУНДГОВЬ АЙМГИЙН
# БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН
# ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 04 сарын 09 өдөр Дугаар А/19 Мандалговь

Байгууллагын гэр бүл, хүүхэд, залуучуудын
хөгжлийг дэмжих зөвлөл шинэчлэн
байгуулах тухай

Монгол улсын Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 6, 7 дугаар зүйл, 18 дугаар зүйлийн 18.1, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3.3-12.3.5, аймгийн Засаг даргын 2015 оны 10 сарын 27-ны өдрийн А/418 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Газрын гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийг дэмжих зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Зөвлөлийн дарга: -Усны нөөцийн ашиглалт, хамгаалалт, ойн бодлого, төрийн бус байгууллага, тогтоол шийдвэр хариуцсан мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга: -Аялал жуулчлал, гадаад хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн

Гишүүдэд:
-Орчны бохирдолт, химийн хорт бодис, байгалийн гамшиг, уур амьсгалын өөрчлөлт дотоод ажил хариуцсан мэргэжилтэн
-Нягтлан бодогч
- Газар, газрын хэвлий, түүний баялгийн ашиглалт, нөхөн сэргээлт, хөрсний доройтол (цөлжилт), байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хариуцсан мэргэжилтэн

2. Байгууллагын гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийг дэмжих зөвлөлийн ажиллах журмыг мөрдлөг болгон төрөл бүрийн арга хэмжээг идэвх санаачилгатай зохион байгуулж, журмын хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр тайлагнаж ажиллахыг зөвлөлийн даргад үүрэг болгосугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Газрын даргын 2018 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн “Байгууллагын гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийг дэмжих зөвлөл байгуулах тухай” А/10 дугаар тушаалын 2 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА Н.ГАНТУЛГА

БАТЛАВ
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ГАЗРЫН ДАРГА Н.ГАНТУЛГА

2024 оны 01 сарын 26

БАЙГУУЛЛАГЫН ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ
ЗӨВЛӨЛИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Эх үүсвэр төсөв (сая.төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хугацаа | Хариуцах эзэн |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. Гэр бүл, хүүхдийн хөгжил, хамгааллын чиглэлээр | | | | | | | |
| 1.1 | Байгууллагын ажилтан, албан хаагчдын гэр бүлийн гишүүдийн нарийвчилсан судалгааг шинэчлэх | - | Баяжуулалт хийсэн эсэх Тийм-1 Үгүй-0 | 1 | 1 | I улиралд | Мэргэжилтэн Б.Цэрэнсугир |
| 1.2 | Олон улсын гэр бүлийн өдөр, Хүүхдийн эрхийг хамгаалах өдрийн хүрээнд байгууллагын албан хаагчдын гэр бүл, хүүхдүүдийн дунд арга хэмжээ зохион байгуулах | ОНТ 0.3 | Хамрагдсан хүний тоо | 45 | 50 | II улиралд | Зөвлөлийн гишүүд |
| 1.3 | Гэр бүлийн харилцааны сургалтад албан хаагчдыг хамруулах | - | Сургалтын тоо | 1 | 1 | II улиралд | Б.Цэрэнсугир |
| 1.4 | Хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга сургалтад хамрагдах | - | Сургалтад хамрагдсан хүний тоо | - | 27 | II улиралд | А.Ганцэцэг |
| 1.5 | Аавуудын өдрийн хүрээнд “Аавууд хүүхдээ хэр сайн мэдэх вэ” контент бэлтгэн түгээх | - | Хамрагдсан албан хаагчдын тоо | 0 | 5 | III улиралд 8.8 | Б.Нямтуяа |

| 2. Залуучуудын хөгжлийг дэмжих чиглэлээр | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.1 | “Good deeds day” сайн үйлсийн аянд нэгдэх | Албан хаагчид 0.3 | Арга хэмжээний тоо | - | 1 | II улиралд | А.Ганцэцэг |
| 2.2 | Байгууллагын албан хаагчдад “Багаар ажиллах, илтгэх ур чадварын сургалт зохион байгуулах | - | Сургалтад хамрагдсан албан хаагчдын хувь | - | 100 | III-р улиралд | Б.Нямтуяа |
| 2.3 | “Үнэт баялаг-Ус” reel challenge зарлах | - | Хамрагдсан ААН, байгууллагын тоо | - | 10 | II-р улиралд | Зөвлөлийн гишүүд |
| 2.4 | Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль, Жендерийн эрх тэгш байдлыг хангах хуулиар сургалтад хамруулах | - | Хамрагдсан албан хаагчдын тоо | - | 20 | III-р улиралд | Б.Батхүү |
| 2.5 | Ажлын байрны дасгал хөдөлгөөнийг хийж хэвшүүлэх | - | Дасгал хийсэн тоо | - | 12 | I-IV улиралд | Зөвлөлийн гишүүд |
| 2.6 | Байгууллагын албан хаагчдыг спортоор хичээллэхийг дэмжих, уралдаан зохион байгуулах | Албан хаагчид 0.5 | Зохион байгуулсан уралдаан тэмцээний тоо | 1 | 2 | I-IV улиралд | Б.Батхүү |

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ЗӨВЛӨЛ